

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/35/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Алтай хот</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546      Цахим хаяг: <a href="mailto:Bujinkhandj@audit.gov.mn">Bujinkhandj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: С.Санчирмаа Утас:99282488      Цахим хаяг: <a href="mailto:Sanchirmaas@audit.gov.mn">Sanchirmaas@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 49  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилтанд илүү цагийг бүртгэлгүй олгосон, тээвэр шатахууны зардлаас анхан шатны баримтгүй зарцуулсан, санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт илүү, дутуу зөрүүтэй, он дамнасан авлага, өглөгийг барагдуулаагүй, зэрэг 15.7 сая төгрөгийн зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Татварын ерөнхий хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07720128

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,955,622.94	263,160,443.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	31,207.88
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	31,207.88
31210	Төгрөг	0.00	31,207.88
31211	Төрийн сангийн харилцах	0.00	394.88
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	30,813.00
33	АВЛАГА	3,709,677.37	227,760,677.37
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	224,051,000.00
33500	Бусад авлага	3,709,677.37	3,709,677.37
33510	Байгууллагаас авах авлага	3,709,677.37	3,709,677.37
35	БАРАА МАТЕРИАЛ	21,245,945.57	35,368,557.82
35100	Түүхий эд материал	5,777,280.60	4,626,313.90
35110	Тусгай зориулалттай материал	2,822,500.00	2,767,500.00
35130	Эм боох материал	2,954,780.60	1,858,813.90
35400	Хангамжийн материал	11,848,814.97	27,556,775.92
35410	Бичиг хэргийн материал	2,285,902.67	1,037,474.67
35420	Аж ахуйн материал	5,359,368.00	25,812,824.25
35430	Сэлбэг хэрэгсэл	1,302,950.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	1,178,500.00	133,127.00
35450	Барилгын засварын материал	241,452.30	0.00
35460	Хүнсний материал	1,452,642.00	573,350.00
35470	Бусад хангамжийн материал	28,000.00	0.00
35600	Мал амьтад	3,619,850.00	3,185,468.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	329,492,224.30	367,179,131.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	329,492,224.30	367,179,131.44
39200	Биет хөрөнгө	323,896,224.30	361,643,131.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	202,084,166.96	202,084,166.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,707,992.63	-30,858,080.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,880,000.00	40,264,613.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,761,666.95	-29,240,384.78
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	295,038,401.50	371,519,715.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-168,769,272.71	-195,751,322.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,535,163.80	27,412,085.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,528,825.67	-24,063,910.56
39217	Ном	126,250.00	276,250.00
39300	Биет бус хөрөнгө	5,596,000.00	5,536,000.00
39301	Программ хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-610,000.00	-670,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,356,000.00	5,356,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	354,447,847.24	630,339,574.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	410,000.00	67,493,342.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	410,000.00	67,493,342.00
41300	Өглөг	410,000.00	67,493,342.00
41360	Бусад өглөг	410,000.00	67,493,342.00
41361	Байгууллагад төлөх өглөг	410,000.00	67,493,342.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	354,037,847.24	562,846,232.51
51	Засгийн газрын хувь оролцоо	354,037,847.24	562,846,232.51
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	277,842,408.90	277,842,408.90
51200	Хуримтлагдсан үр дүн	37,582,706.75	246,391,092.02
51210	Өмнөх үеийн үр дүн	63,894,388.05	37,582,706.75
51220	Тайлант үеийн үр дүн	-26,311,681.30	208,808,385.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,612,731.59	38,612,731.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	354,447,847.24	630,339,574.51

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	436,550,089.10	1,116,300,514.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,136,077.10	262,934,807.13
120	Нийтлэг татварын бус орлого	34,136,077.10	262,934,807.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,780,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,780,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	94,744,316.65
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,356,077.10	168,190,490.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,414,012.00	853,365,707.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	349,247,800.00	382,896,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,247,800.00	382,896,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,852,032.00	426,973,767.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,765,332.00	29,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	86,700.00	30,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	397,543,767.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,209,000.00	33,526,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,209,000.00	33,526,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,105,180.00	9,969,840.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,105,180.00	9,969,840.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	462,861,770.40	907,492,128.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462,861,770.40	907,492,128.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,857,948.89	876,417,821.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,064,863.99	358,839,402.12
210101	Үндсэн цалин	179,789,999.84	234,584,203.56
210102	Нэмэгдэл	72,000,000.00	76,799,999.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,300,000.00	3,234,000.00
210104	Урамшуулал	15,764,864.15	44,221,199.04
210105	Гэрээт ажлын хөлс	210,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,854,980.00	47,699,000.00
210201	Тэтгэврийн даатгал	25,934,980.00	35,383,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,730,000.00	3,079,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,184,000.00	2,463,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	546,000.00	615,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,460,000.00	6,158,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,380,063.50	32,512,566.00
210301	Гэрэл, цахилгаан	2,900,000.00	2,700,000.00
210302	Түлш, халаалт	9,480,063.50	29,416,566.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	396,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,034,791.00	69,410,604.35
210401	Бичиг хэрэг	1,217,900.00	2,661,030.00
210402	Тээвэр, шатахуун	12,394,000.00	21,942,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	700,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	7,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	545,920.00	1,137,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,790,650.00	42,768,452.35

210408	Бараа материал акталсны зардал	486,321.00	192,862.00
2105	Нормативт зардал	36,269,193.00	279,861,670.58
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,369,727.00	212,749,016.58
210502	Хоол, хүнс	7,626,466.00	34,343,814.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,273,000.00	32,768,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,030,200.00	4,832,302.30
210604	Урсгал засвар	1,030,200.00	4,832,302.30
2107	Томилолт, зочны зардал	424,000.00	459,057.00
210702	Дотоод албан томилолт	424,000.00	459,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,026,112.00	9,170,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,242,262.00	7,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	774,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	40,000.00	60,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	270,000.00	297,000.00
210807	Газрын төлбөр	0.00	20,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	587,350.00	740,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,773,745.40	73,633,219.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,813,500.00	10,937,010.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,960,245.40	62,696,209.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,003,821.51	31,074,307.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,487,930.00	31,024,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,487,930.00	31,024,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	91,741.51	50,307.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,741.51	50,307.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,100.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,100.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-26,311,681.30	208,808,385.27
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-26,311,681.30	208,808,385.27

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Зүүллэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,842,408.90	38,612,731.59	63,894,388.05	380,349,528.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	277,842,408.90	38,612,731.59	63,894,388.05	380,349,528.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-26,311,681.30	-26,311,681.30
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,842,408.90	38,612,731.59	37,582,706.75	354,037,847.24
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	277,842,408.90	38,612,731.59	37,582,706.75	354,037,847.24

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	277,842,408.90	38,612,731.59	37,582,706.75	354,037,847.24
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	208,808,385.27	208,808,385.27
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	277,842,408.90	38,612,731.59	246,391,092.02	562,846,232.51

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	402,414,012.00	629,314,707.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,414,012.00	629,314,707.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	349,247,800.00	382,896,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,247,800.00	382,896,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,852,032.00	202,922,767.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,765,332.00	29,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	86,700.00	30,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	173,492,767.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,209,000.00	33,526,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,209,000.00	33,526,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,105,180.00	9,969,840.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,105,180.00	9,969,840.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	400,925,012.00	623,644,699.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	400,925,012.00	623,644,699.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,921,190.49	592,570,392.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,854,863.99	358,839,402.12
210101	Үндсэн цалин	179,789,999.84	234,584,203.56
210102	Нэмэгдэл	72,000,000.00	76,799,999.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,300,000.00	3,234,000.00
210104	Урамшуулал	15,764,864.15	44,221,199.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,854,980.00	47,699,000.00
210201	Тэтгэврийн даатгал	25,934,980.00	35,383,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,730,000.00	3,079,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,184,000.00	2,463,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	546,000.00	615,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,460,000.00	6,158,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,089,862.50	32,645,693.00
210301	Гэрэл, цахилгаан	2,900,000.00	2,700,000.00
210302	Түлш, халаалт	9,189,862.50	29,549,693.00

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	0.00	396,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,779,620.00	22,341,750.00
210401	Бичиг хэрэг	1,226,700.00	1,148,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,488,900.00	16,132,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	1,000,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	545,920.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	918,100.00	3,430,950.00
2105	Нормативт зардал	26,278,652.00	107,978,880.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,516,202.00	51,431,900.00
210502	Хоол, хүнс	6,763,450.00	22,291,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,999,000.00	34,255,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,155,200.00	3,707,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	125,000.00	185,000.00
210604	Урсгал засвар	1,030,200.00	3,522,600.00
2107	Томилолт, зочны зардал	424,000.00	459,057.00
210702	Дотоод албан томилолт	424,000.00	459,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,326,512.00	9,434,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,452,262.00	7,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	774,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	40,000.00	60,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	270,000.00	391,000.00
210807	Газрын төлбөр	0.00	20,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	180,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	677,750.00	731,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,157,500.00	9,464,310.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,157,500.00	9,464,310.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,003,821.51	31,074,307.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,487,930.00	31,024,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,487,930.00	31,024,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	353,050.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	353,050.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	91,741.51	50,307.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,741.51	50,307.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,100.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,100.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,489,000.00	5,670,007.88
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,489,000.00	5,638,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,489,000.00	5,638,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,489,000.00	5,638,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,489,000.00	5,638,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,489,000.00	-5,638,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	31,207.88
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	31,207.88
----	---	------	-----------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төсвийн хэмнэлт, хэтрэлт	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	440,466,100.00	426,341,238.12	14,124,861.88	97%
УРСГАЛ ЗАРДАЛ	440,466,100.00	426,341,238.12	14,124,861.88	97%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439,466,100.00	425,341,238.12	14,124,861.88	97%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,900,000.00	307,436,739.12	463,260.88	100%
Үндсэн цалин	193,600,000.00	193,136,740.56	463,259.44	100%
Нэмэгдэл	76,800,000.00	76,799,999.52	0.48	100%
Унаа хоолны хөнгөлөлт	3,000,000.00	3,000,000.00	0.00	100%
Урамшуулал	34,500,000.00	34,499,999.04	0.96	100%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,566,500.00	41,566,500.00	0.00	100%
Тэтгэврийн даатгал	29,250,500.00	29,250,500.00	0.00	100%
Тэтгэмжийн даатгал	3,079,000.00	3,079,000.00	0.00	100%
ҮОМШӨ-ний даатгал	2,463,200.00	2,463,200.00	0.00	100%
Ажилгүйдлийн даатгал	615,800.00	615,800.00	0.00	100%
Эрүүл мэндийн даатгал	6,158,000.00	6,158,000.00	0.00	100%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,500,000.00	32,449,693.00	50,307.00	100%
Гэрэл, цахилгаан	2,700,000.00	2,700,000.00	0.00	100%
Түлш, халаалт	29,600,000.00	29,549,693.00	50,307.00	100%
Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00	0.00	100%
Хангамж, бараа материалын зардал	18,877,500.00	18,838,600.00	38,900.00	100%
Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100%
Тээвэр, шатахуун	15,027,500.00	15,027,500.00	0.00	100%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,020,000.00	1,000,000.00	20,000.00	98%
Ном, хэвлэл	150,000.00	150,000.00	0.00	100%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	480,000.00	0.00	100%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,181,100.00	18,900.00	98%
Нормативт зардал	24,000,000.00	11,215,806.00	12,784,194.00	47%
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,000,000.00	8,267,806.00	7,732,194.00	52%
Хоол, хүнс	6,000,000.00	2,565,900.00	3,434,100.00	43%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	382,100.00	1,617,900.00	19%
Эд хогшил, урсгал засварын зардал	4,284,900.00	4,284,800.00	100.00	100%
Багаж, техник, хэрэгсэл	3,258,900.00	3,258,800.00	100.00	100%
Урсгал засвар	1,026,000.00	1,026,000.00	0.00	100%
Томилолт, зочны зардал	640,000.00	202,000.00	438,000.00	32%
Дотоод албан томилолт	640,000.00	202,000.00	438,000.00	32%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,084,800.00	1,734,700.00	350,100.00	83%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.00	240,000.00	240,000.00	50%
Даатгалын үйлчилгээ	115,000.00	79,500.00	35,500.00	69%
Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	60,000.00	0.00	100%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	58,600.00	33,000.00	25,600.00	56%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	391,000.00	9,000.00	98%

**Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Газрын төлбөр	20,000.00	20,000.00	0.00	100%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	220,000.00	180,000.00	40,000.00	82%
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	731,200.00	731,200.00	0.00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	7,612,400.00	7,612,400.00	0.00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	7,612,400.00	7,612,400.00	0.00	100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100%
Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>440,466,100.00</b>	<b>426,391,940.00</b>	<b>14,074,160.00</b>	<b>97%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>382,896,100.00</b>	<b>382,896,100.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	382,896,100.00	382,896,100.00	0.00	100%
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>33,526,000.00</b>	<b>33,526,000.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
Орон нутгийн төсвөөс	33,526,000.00	33,526,000.00	0.00	100%
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>24,044,000.00</b>	<b>9,969,840.00</b>	<b>14,074,160.00</b>	<b>41%</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,044,000.00	9,969,840.00	14,074,160.00	41%
"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	394.88	<b>-394.88</b>	0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	202,891,954.0
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	202,891,954.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	172,867,954.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	51,402,663.00
Үндсэн цалин		41,447,463.00
Унаа хоолны хөнгөлөлт		234,000.00
Урамшуулал		9,721,200.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	6,132,500.00
Тэтгэврийн даатгал		6,132,500.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	196,000.00
Цэвэр, бохир ус		196,000.00
Хангамж, бараа материалын зардал	-	3,503,150.00
Бичиг хэрэг		148,500.00
Тээвэр, шатахуун		1,104,800.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,249,850.00
Нормативт зардал	-	96,763,074.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		43,164,094.00
Хоол, хүнс		19,725,180.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		33,873,800.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,061,600.00
Багаж, техник, хэрэгсэл		2,565,000.00
Урсгал засвар		2,496,600.00
Томилолт, зочны зардал	-	257,057.00
Дотоод албан томилолт		257,057.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,700,000.00

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,700,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,851,910.00
Бараа үйлчилгээний бусад зардал		1,851,910.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	30,024,000.00
Бусад урсгал шилжүүлэг	-	30,024,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		30,024,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	202,922,767.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	202,922,767.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	29,400,000.00
ЭМД сангийн нэмэлт орлого		173,522,767.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>30,813.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Эмнэлгийн ажилчдын харьцаа хандлага, ур чадварыг дээшлүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулна” хэмээн зорилгоо тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 462.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 905.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14.5 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78 хувиар буюу 275.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 227.8 сая төгрөг болж өссөн нь гүйцэтгэлээр санхүүжиж нийгмийн даатгалын хэлтэс, байгууллагаас авах авлагатай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 35.4 сая төгрөг болж 14.1 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн

хөрөнгөөр 213.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 167.9 сая төгрөгийн үнэ төлбөргүйгээр хүлээн авч үйл ажиллагаандаа 367.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 367.2 сая төгрөг болж 37.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 94.7 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тавилга, машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой.

Тайлант онд Эрүүл мэндийн газраас 5.4 сая төгрөгийн 3 мотоцикл, 10.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн яамнаас 1.3 сая төгрөгийн төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлж авч хандиваар 77.8 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

Өглөг дансны үлдэгдэл 67.5 сая төгрөг болж өссөн нь байгууллагад өгөх өглөгтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 564.8 сая төгрөг болж 208.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 2.5 дахин буюу 680.0 сая төгрөгөөр өссөн нь санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 246.4 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 368.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 72.0 сая төгрөгөөр өсгөж, 440.5 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төслөөс батлагдсан төсөв их байгаа нь цалингийн зардал нэмэгдсэнтэй холбоотой.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 440.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 382.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 33.5 сая төгрөгийн, нийгмийн даатгалын сангаас 24.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 426.3 сая төгрөгийг зарцуулж 0.03 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 426.3 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь ажил олгогчоос цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 0.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.05 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.04 сая төгрөгөөр, норматив зардал 12.8 сая төгрөгөөр, томилот зочны зардлыг 0.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх зардлыг 0.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 202.9 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба дээд шатны төсөв захирагчаас 29.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 173.5 сая төгрөгийн орлогыг тайлагнаж, урсгал үйл ажиллагаанд 202.8 сая төгрөгийг зарцуулсан, 0.03 сая төгрөгийг үлдэгдэлтэй. Нэмэлт санхүүжилтийн орлогыг цалин хөлс, хангамж, бараа материал, томилот, зочны, бусдаар гүйцэтгүүлэх, нэг удаагийн тэтгэмж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-баримт, худалдан авах ажиллагааг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 1,092.3 сая төгрөгийн 41 мэдээллийг ил тод байршуулахаас 24.3 сая төгрөгийн 10 мэдээллийг ил тод байршуулж, 1,067.9 сая төгрөгийн 31 мэдээллийг мэдээлээгүй байсныг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна.

### 3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 7.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй байна.

### 3.9.3 И-баримттай холбоотой

И-баримтгүй 87.6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 34.8 сая албан шаардлага хүргүүлж, 21.1 сая төгрөгийн зөвлөмжийг өгснөөс 3.7 сая төгрөгийн шийдвэр хууль хяналтын байгууллагын шатанд явагдаж байгаа.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар аудитаар:

- ✓ Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэх
- ✓ Илүү цагийн бүртгэлийг тулган баталгаажуулах, авлага, өглөгийн барагдуулалтыг үзэх
- ✓ Он дамнасан шүүхийн шийдвэрийн цалингийн нөхөн олговортой холбоотой 3.7 сая төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллагад хандсаныг үзэх
- ✓ Эмийн нэр төрлийн тайланг бөөн дүнгээр зарлагаддаг "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар шийдвэр өгөгдсөн тул дараагийн аудитаар уг зөрчил арилсан эсэхийг үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 468.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 357.3 сая төгрөгийн алдааг залруулж, 0.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 109.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 заалт зөвлөмжийг өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Нэр бүхий 2 компаниас 6.3 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

#### 4.2 Төлбөрийн акт

Илүү цагийн хөлсийг 0.6 сая төгрөгөөр илүү тооцоолж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар 50.2-т "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тээвэр шатахууны зардлаас 0.2 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Тендерт шалгараагүй иргэн ААНБ-аас 7.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 1.8 сая төгрөгийн илүү, 12.4 сая төгрөгийн дутуу зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

И-баримтгүй 87.6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Он дамнасан 0.2 сая төгрөгийн авлага, 0.4 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн

заалттай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Үүнд:

##### 1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 41 мэдээлэл мэдээлэхээс 31 мэдээлэл хоцроож мэдээлсэн.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг мөрдөн мэдээллээ бүрэн оруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн	8	468.0	2	357.3	2	0.8	4	109.9	1	0